

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2024 оны төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин
НЭГ. “ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН 2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ” ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫН ХҮРЭЭНД					
1	“Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 75 дугаар зүйлийг чанд мөрдөж ажиллах	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
2	Гадаадад айлчлах, албан хэргээр зорчих, олон улсын арга хэмжээнд оролцох, албан ёсны яриа хэлэлцээ ядуулахдаа 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийг чанд мөрдөж ажиллах, түүнчлэн удирдамжийн төсөл, (удирдамжид айлчлалын ач холбогдолыг, тусгасан байх), зардлын төсөв боловсруулж, Гадаад харилцааны яаманд арга хэмжээ болхоос 10-аас доошгүй өдрийн өмнө хүргүүлж санал авч байх	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
3	Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ыг чанд мөрдөж ажиллах, ингэхдээ өөрийн эрх хэмжээний асуудлаар гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай гэрээ байгуулах тохиолдолд гэрээг байгуулахаасаа 10 хоногийн өмнө уг гэрээний төслийг хянуулж, гэрээ байгуулах зөвшөөрөл авхаар гэрээний төслийг байгуулах зөвшөөрөл авхаар гэрээний төслийг холбогдох материалын хамт Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газарт хүргүүлэх	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%

4	Гадаад улсын хот,орон нутагтай хөгжүүлж буй харилцааны эрчийг хадгалах, хамтын ажиллагааны баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
5	Гадаад улсын төрийн байгууллага болон аж ахуйн нэгж,олон улсын байгууллагатай уулзахдаа Монгол улсын гадаад бодлогын байр суурийн хүрээнд ярилцах, ярианы сэдвийг урьдчилан боловсруулж Гадаад харилцааны яамнаас санал авч байх	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
6	Худийн хэргээр гадаад улсад зорчихдоо албан ёсны уулзалт, яриа хэлэлцээ хийх, гэрээ байгуулах, ёслолын арга хэмжээнд оролцохгүй байх	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
7	Гадаад улсад албан ёсны, эсхүл ажлын айлчлал хийсэн, албан хэргээр зорчсон, олон улсын арга хэмжээнд оролцсон, албан ёсны яриа хэлэлцээ явуулсан тухай илтгэх хуудасны хувийг ажлын 7 хоногийн дотор Гадаад харилцааны яаманд ирүүлэх	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
8	Гадаад хамтын ажиллагааны 2022 оны тайланг гадаад арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн хамт 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор, 2023 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Гадаад харилцааны яаманд ирүүлэх	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
9	“Монгол Улсын Дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-д заасан албан паспорт эзэмших эрхтэй этгээдэд албан паспорт мэдүүлэх	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
10	“Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг чанд мөрдөх, хяналт тавих, тайлан, мэдээллийг тогтоосон хугацаанд Гадаад харилцааны яаманд ирүүлэх	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	100%
11	Гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагуудад орон нутгийг танилцуулах суртчилгаа, соёлын арга хэмжээг зохион байгуулахад Гадаад харилцааны яамтай хамтран ажиллах	БӨХ	Хэрэгжилтийн хувь 100%	0%	70%

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН 2024 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			
		Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар /
НЭГ. “ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД, ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН 2022 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ” ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫН ХҮРЭЭНД					
1	“Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 01/01 дүгээр зөвлөмж, Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 75 дугаар зүйлийг чанд мөрдөж ажиллах	БӨХ	Хэрэгжилтийг хангаж ажилласан байх	Хэрэгжилтийг хангаж ажилласан байх	Аймгийн Засаг дарга болон түүний Тамгын газар нь төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлж буй Холбогдох хууль, тогтоол, журам, зөвлөмжийг чанд мөрдөн ажилласан болно. Хэрэгжилт 100.0 хувь
2	Гадаадад айлчлах, албан хэргээр зорчих, олон улсын арга хэмжээнд оролцох, албан ёсны яриа хэлэлцээ ядуулахдаа 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон “Төрийн хэмнэлтийн тухай” хуулийг чанд мөрдөж ажиллах, түүнчлэн удирдамжийн төсөл, (удирдамжид айлчлалын ач холбогдлыг, тусгасан байх), зардлын төсөв боловсруулж,	БӨХ	Зөвшөөрөл, саналыг авсан байх	Дээд шатны байгууллагад хандан зөвшөөрөл, саналыг авч, удирдамж, төсвийг батлуулсан байх	Оросын Холбооны Улсын Бүгд Найрамдах Тува Улс, Бүгд Найрамдах Хакас Улс руу хийх албан айлчлалын хүрээнд аймгийн Засаг даргын 1/101 дугаартай албан бичгээр зөвшөөрөл авч, удирдамж, хөтөлбөрийг боловсруулан батлуулж ажилласан байна. Хэрэгжилт 100.0 хувь

	Гадаад харилцааны яаманд арга хэмжээ болохоос 10-аас доошгүй өдрийн өмнө хүргүүлж санал авч байх				
3	Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ыг чанд мөрдөж ажиллах, ингэхдээ өөрийн эрх хэмжээний асуудлаар гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай гэрээ байгуулах тохиолдолд гэрээг байгуулахаасаа 10 хоногийн өмнө уг гэрээний төслийг хянуулж, гэрээ байгуулах зөвшөөрөл авахаар гэрээний төслийг байгуулах зөвшөөрөл авахаар гэрээний төслийг холбогдох материалын хамт Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газарт хүргүүлэх	БӨХ	Гэрээний төсөл, гэрээний танилцуулгыг бэлтгэсэн байх	Гэрээний төсөл, гэрээний танилцуулгыг бэлтгэн ЗГХЭГ-аас санал аван гадаад харилцааны яаманд хүргүүлсэн байх	ОХУ-ын БНТува улстай хийх Худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, техник, шинжлэх ухаан, боловсрол, соёлын салбарын хамтын ажиллагаа болон “Ойг хортон шавжаас хамгаалах, хилийн бүс нутагт ойн өвчлөл, ойн түймрээс хамгаалах талаар хамтран ажиллах тухай” гэрээг ЗГХЭГ-аас санал аван гэрээний танилцуулгын хамт Гадаад харилцааны яамны гэрээ эрх зүйн газраар хянуулан гэрээ байгуулах зөвшөөрлийг Гадаад харилцааны яамны 09/5730 дугаартай албан бичгээр авч ажилласан байна. Хэрэгжилт 100.0 хувь
4	Гадаад улсын хот, орон нутагтай хөгжүүлж буй харилцааны эрчийг хадгалах, хамтын ажиллагааны баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах	БӨХ	Хамтын ажиллагаатай орон нутагтай мэдээ мэдээлэл байнга солилцдог байх	Хамтын ажиллагаатай орон нутагтай мэдээ мэдээлэл байнга солилцож, баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажилласан байна	Аймгийн Засаг дарга түүний Тамгын газар нь Гадаад улсын хот, орон нутагтай хөгжүүлж буй харилцааны эрчийг хадгалах, хамтын ажиллагааны баримт бичгийн хэрэгжилтийг ханган тайлан мэдээг Гадаад харилцааны яам руу тухай бүр хүргүүлэн ажилласан. Хэрэгжилт 100,0 хувь
5	Гадаад улсын төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, олон улсын байгууллагатай уулзахдаа Монгол улсын гадаад	БӨХ	Ярианы сэдвийн төсөл бэлтгэх	Ярианы сэдвийн төслийг бэлтгэн Гадаад харилцааны	Оросын холбооны Улсын Бүгд Найрамдах Тува, Бүгд Найрамдах Хакас Улс руу 2024 оны 02 дугаар сарын 13-18-ны хооронд албан айлчлалын уулзалтад ярилцах ярианы

	бодлогын байр суурийн хүрээнд ярилцах, ярианы сэдвийг урьдчилан боловсруулж Гадаад харилцааны яамнаас санал авч байх			яамнаас санал авсан байх	сэдвийг урьдчилан боловсруулж Гадаад харилцааны яамнаас санал авч ажилласан болно. Хэрэгжилт 100.0 хувь
6	Хувийн хэргээр гадаад улсад зорчихдоо албан ёсны уулзалт, яриа хэлэлцээ хийх, гэрээ байгуулах, ёслолын арга хэмжээнд оролцохгүй байх	БӨХ	Хувийн хэргээр гадаадад зорчихдоо албан ёсны үйл ажиллагаанд оролцохгүй байх	Хувийн хэргээр гадаадад зорчихдоо албан ёсны үйл ажиллагаанд оролцохгүй байна	Аймгийн Засаг дарга хувийн хэргээр гадаадад зорчихдоо албан ёсны уулзалт, яриа хэлэлцээ хийх, гэрээ хэлцэл байгуулах, ёслолын арга хэмжээнд оролцоогүй болно. Хэрэгжилт 100,0 хувь
7	Гадаад улсад албан ёсны, эсхүл ажлын айлчлал хийсэн, албан хэргээр зорчсон, олон улсын арга хэмжээнд оролцсон, албан ёсны яриа хэлэлцээ явуулсан тухай илтгэх хуудасны хувийг ажлын 7 хоногийн дотор Гадаад харилцааны яаманд ирүүлэх	БӨХ	Илтгэх хуудсыг бэлтгэх	Илтгэх хуудсыг заасан хугацаанд гадаад харилцааны яаманд хүргүүлэх	Оросын холбооны Улсын Бүгд Найрамдах Тува, Бүгд Найрамдах Хакас Улс руу 2024 оны 02 дугаар сарын 13-18-ны өдрүүдэд албан айлчлал хийсэн илтгэх хуудсыг Гадаад харилцааны яаманд хүргүүлэн ажилласан болно. Хэрэгжилт 100.0 хувь
8	Гадаад хамтын ажиллагааны 2023 оны тайланг гадаад арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн хамт 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор, 2024 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Гадаад харилцааны яаманд ирүүлэх	БӨХ	Тайлан болон төлөвлөгөөг бэлтгэх	Тайлан болон төлөвлөгөөг заасан хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэх	Гадаад хамтын ажиллагааны 2023 оны тайланг гадаад арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн хамт гарган нэг дүгээр сард, 2024 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг гарган Гадаад харилцааны яамны dep01-4@mfa.gov.mn хаягаар хүргүүлэн ажилласан байна. Хэрэгжилт 100,0 хувь
9	“Монгол Улсын Дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-д заасан албан паспорт эзэмших эрхтэй этгээдэд албан паспорт мэдүүлэх	БӨХ	Журамд нийцсэн албан паспортыг Гадаад харилцааны яаманд мэдүүлэх	Журамд нийцсэн албан паспортыг Гадаад харилцааны яаманд мэдүүлж паспортыг гаргуулах	2023 онд албан дипломат албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журамд заасан албан паспорт эзэмших эрхтэй 4 албан хаагчид албан гадаад паспортыг олгуулж, 5 албан хаагчийн албан гадаад паспортын мэдүүлгийг Гадаад харилцааны яамны Консулын газарт мэдүүлж, 5 албан хаагчийн гадаад паспортыг гаргуулан ажилласан болно.

					Хэрэгжилт 100,0 хувь
10	“Монгол Улсын дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журам”-ыг чанд мөрдөх, хяналт тавих, тайлан, мэдээллийг тогтоосон хугацаанд Гадаад харилцааны яаманд ирүүлэх	БӨХ	Тайлан мэдээг гаргасан байх	Тайлан мэдээг гарган Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн байх	Дипломат, албан гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журмын дагуу албан гадаад паспортын материалуудыг бүрдүүлэн Гадаад харилцааны яамны Консулын газарт илгээсэн, хүчинтэй байгаа паспортуудын судалгааг гарган ажиллаж байна. Хэрэгжилт 100,0 хувь айна.
11	Гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагуудад орон нутгийг танилцуулах сурталчилгаа, соёлын арга хэмжээг зохион байгуулахад Гадаад харилцааны яамтай хамтран ажиллах	БӨХ	Арга хэмжээ зохион байгуулсан байх	Арга хэмжээ зохион байгуулан ажилласан байна	Олон улсын байгууллагуудад орон нутгийг танилцуулах сурталчилгаа, соёлын арга хэмжээг зохион байгуулахаар Завхан аймгийн тухай ерөнхий мэдээлэл газар нутаг, хүн ам, айл өрх, малын тоо толгой, эдийн засгийн ерөнхий байдал зэргийг тусгасан брошюрыг орос, хятад, англи хэл дээр хөрвүүлэн Гадаад харилцааны яам руу хүргүүлэхээр бэлтгэн ажиллаж байна. Хэрэгжилт 70,0 хувь
Нийт					Хэрэгжилт 97,2 хувь

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР